

ЛАМЫН ГЭГЭЭНИЙ ОРЧУУЛСАН НЭГЭН ТОЛЬ
БИЧГИЙН ОНЦЛОГ

Д.Бүрнээ¹

Монгол оронд бурханы шашныг дэлгэрүүлэхэд буддын утга зохиолын орчуулга чухал үүрэгтэй байсан бөгөөд энэ үйл хэрэгт монголын үе үеийн мэргэд, бичгийн хүмүүс их зүйлийг хийжээ. Тэдгээр мэргэдийн нэг болох Ламын гэгээн Лувсанданзанжалцангийн (1639-1704) монгол орчуулгын түүхэнд оруулсан хувь нэмрийн тухай буюу тодруулбал төвд хэлнээс монгол хэлнээ орчуулсан нэгэн толь бичгийнх нь тухай энд өгүүлэхийг зорьсон болно.

Зая бандид Лувсанпэрэнлэй (1642-1715) төвд хэлээр бичсэн "Товъёг салви мэлон"² хэмээх зохиолынхоо 4 дүгээр ботид Ламын гэгээний намтрыг бичих дашрамд түүний орчуулгын үйлсийн талаар тэмдэглэжээ. Үүнийг эш татвал *stag lo'i cho 'phrul smon lam gyi bsgang la khu re' chen mor phebs, de skabs lo tsaA ba mang po 'tshogs pa'i skabs rje 'di pa'i dbus mdzad de lo tsaA ba rnams kyis dag yig za ma tog sog skad du bskyr*³, орчуулбал "бар жилийн рид хувилгааны ерөөлийн үеэр Их Хүрээнд ирэв. Тэр үед олон хэлмэрч чуулсан үес мөнхүү богд тэргүүлэн хэлмэрч нар Даг ег са ма дог-ийг орчуулав" гэжээ. Энэ судрыг орчуулахад Өндөр гэгээн оролцсон тухай бичсэнийг мөн эш татвал *stag lo'i cho 'phrul smon lam grol skabs su gyon ru tsho pa bzhi'i lo tsaA shes mkhan bzhugs sgar la 'bod pa gngang nas thams cad kyi bgros mthun thog nas dag yig za ma tog sog skad du bsgyur*⁴ гэжээ. Үүнийг орчуулбал "барс жилийн рид хувилгааны ерөөл төгсөх үеэр зүүн дөрвөн хошууны мэргэн хэлмэрчдийг хүрээндээ дуудав. Хамаг бүгд зөвшин хэлэлцэж, "Даг ег са ма дог"-ийг монгол хэлнээ орчуулав" гэжээ. Үүнээс үзвэл тус судрыг монгол хэлнээ орчуулахыг Өндөр гэгээн санаачилж, Ламын гэгээн тэргүүтэй мэргэд төвд хэлнээс эх монгол хэлнээ хөрвүүлжээ. Энд дурдсан барс жил бол 1686 он юм⁵. Монголын шашны тэргүүн болон номт мэргэдийн ийнхүү анхааран авч орчуулсан ном бол төвдийн эрдэмтэн Шалу Ринчэнчойжонсамбуу (1444-1527) -гийн зохиосон *Bod kyi brda'i bstan bcos legs bshad pa rin po che'i za ma tog bkod pa* хэмээх буюу монгол хэлнээ орчуулбал *Төвдийн дохионы шастир сайн номлол эрдэнийн хуурцаг* нэрт судар болно. Шалу

¹ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Энэ зохиолын бүтэн нэр нь *shaA kya'i btsun blo bzang 'phrin las kyi zab pa rgya che ba'i dam pa'i chos kyi thob yig gsal ba'i me long las glebs bam bzhi ba bzhugs so*.

³ *shaA kya'i btsun blo bzang 'phrin las kyi zab pa rgya che ba'i dam pa'i chos kyi thob yig gsal ba'i me long las glebs bam bzhi ba bzhugs so*, 157а тал.

⁴ *shaA kya'i btsun blo bzang 'phrin las kyi zab pa rgya che ba'i dam pa'i chos kyi thob yig gsal ba'i me long las glebs bam bzhi ba bzhugs so*, 71а-71б тал.

⁵ Ш.Бира, Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа, III, Улаанбаатар, 2001, 124-р тал.

Ринчэнчойжонсамбуу тус судрыг 1514 онд зохиосон нь бар болон гар бичмэлээр уламжилж иржээ.

Зая бандид Лувсанпэрэнлэй бээр Шалу Ринчэнчойжонсамбуугийн зохиосон энэ номын нэрийг хураангуйлан "Даг ег са ма дог" хэмээн нэрлэжээ. Гэтэл "Даг ег" гэдэг үг Шалу Ринчэнчойжонсамбуугийн зохиосон номын нэрд байхгүй бөгөөд төвдөөр даг-ег (dag yig) гэж зөв бичих зүйн дүрэм буюу толь бичгийг хэлнэ⁶. Угтаа тус судрыг "Да и данжой са ма дог" буюу орчуулбал "Хуурцаг хэмээх дохионы шастир" гэж хураангуйлан нэрлэж болох боловч агуулгаар нь "Даг ег са ма дог" буюу §"Хуурцаг хэмээх зөв бичгийн дүрэм" (Хуурцаг хэмээх толь бичиг гэж бас орчуулж болно) гэж нэрлэжээ. Өөрөөр хэлбэл бид тус номыг нэрээс нь үүдэж, зөв бичих зүйн дүрэм, эс бөгөөс толь бичиг хэмээн ойлгож болохоор байгаа юм.⁷ Тус судрыг Ш.Сонинбаяр, Л.Хүрэлбаатар нар толь бичиг гэж тодорхойлсонтой бид санал нэг байна.

Ламын гэгээн тэргүүтэй мэргэдийн орчуулсан тус судрын монгол орчуулга хувь хүмүүсийн цуглуулгад байхаас гадна гадаадын зарим орны номын санд хадгалагдаж байна. Тухайлбал, БНХАУ-ын номын санд тус толийн монгол орчуулга бүхий найман зүйл гар бичмэл хадгалагдаж байна⁸. Эдгээр нь

1. Tübed-üyn dokiyan-u ilyal šastir-a say tur nomlay san erdeni yin oki qayur čay joki yaу san kemeg dekü neretü orusi ba, төвд монгол хадмал, Чин улсын Найралт Төвийн гутгаар он, хөхөгчин туулай жилийн хулсан үзгийн бичмэл, 64 хуудас, дундаасаа дутуу, монгол хэлнээ хэн, хэдийд орчуулсан нь тодгүй.
2. Tübed ün dokiyan i sastir sayitur nomlaysan erdeni yin oki saba kemekü, төвд монгол хадмал, Чин улсын дунд үеийн хулсан үзгийн хадмал, эхэн эцсээсээ дутуу, монгол хэлнээ хэн, хэдийд орчуулсан нь тодгүй, хулсан үзгийн бичмэл.
3. Tübed-ün dokiyan-u šastir sayitur nomlaqui erdeni yin oki saba jokiyaysan kemekü ogusiba, тод монгол- төвд хадмал, Чин улсын дунд үед хамаарагдана. В.Хайсигийн "Монгол ном, гар бичмэл, барын номын бүртгэл"-д бас бүртгэгджээ.
4. Tübed-ün dokiyan-u šastir a sayitur nomlay san erdeni yin oki qayurčay joki yaу san kemegde kü oru siba, төвд-монгол хадмал, 35 хуудас, Чин улсын дунд үеийн хадмал, модон үзгийн бичмэл, хэн, хэдийд орчуулсан нь тодгүй,
5. Tübed-ün dokiyan-u šastir a sayitur nomlaysan erdeni yin qayur čay joki yaуsan kemeg dekü neretü orusiba, төвд-монгол хадмал, 55 хуудас.

⁶ Оросын эрдэмтэн Ю.Н.Рерих энэ үгийг "орфография, правописание", төвд, хятад хэлний тайлбар тольд "үсэг бичгийг ариутгах ном" гэж орчуулжээ. "Мэргэд гарахын орон" хэмээх нэр томъёоны толь бичгийг мөн даг-ег гэж төвдөөр нэрлэж, монголоор тогтсон даг-ег гэж орчуулжээ.

⁷ "Товъёг салвий мэлон" хэмээх зохиолын дотор бүхий Өндөр гэгээний намтрын хэд хэдэн монгол орчуулга өнөө үед уламжилж иржээ. Академич Ш.Бира уламжлалт монгол орчуулгад дулдуйдан, (Жэвзундамба Лувсандамбижалцанбалсанбогийн ердийн товч намтар,- Өндөр гэгээний намтрууд оршивой, түвэд хэлнээс орчуулж, эрдэм шинжилгээний тайлбар бичсэн академич Ш.Бира, УБ., 1995, 16-17-р тал) Даг ег са ма дог хэмээх номын нэрийг "Үсгийн хуурцаг" гэж монголчилж, төвд хэлний зүйн ном гэж тодорхойлжээ. Ш.Сонинбаяр Ламын гэгээн голлон удирдаж, "Дагегсамдог" хэмээх толь бичгийг монгол хэлээр орчуулсан (Лавайн эгшиг, ¹ 1, УБ.1998, 17-р тал), Л.Хүрэлбаатар "Ламын гэгээн Их Хүрээнд олон орчуулагч хэлмэрдийг цуглуулж, Ариун бичиг хаши хуурцаг" хэмээх толь бичгийг монгол хэлээр орчуулсан"(Огторгуйн цагаан гарди, II, УБ., 2008, 92-р тал) гэжээ.

⁸ Dumdadu ulus un erten-ü mongyol nom bičig-ün yerünkei yarčay, Vol. II, Begejing nom-un sang keblel-ün qoriy-a, 1999, 1201-1202-р тал

6. Tübed-ün dokiyan-u šastir a sayitur nomlaysan erdeni yin qayur čay joki yaу san kemegdekü orusibai, төвд-монгол хадмал, 34 хуудас, дутуу, Чин улсын дунд үеийн хулсан үзгийн бичмэл, дутуу
7. Tübed-ün dokiyan-u šastir-a sayiqan dur nomlaysan erdeni yin qayurčay joki yaуsan kemegdekü orusiba, Чин улсын дунд үеийн хулсан үзгийн бичмэл.
8. Tübed-ün dokiyan-u šastir sayin nomlalun erdeni yin qayurčay un jokiyal kemekü oru siba, Чин улсын дунд үеийн хулсан үзгийн бичмэл, 44 хуудас, төгсгөлөөс дутуу.

Эдгээр гар бичмэл зонхилон төвд-монгол хадмал судар байхаас гадна монгол орчуулгыг төвд эхийн өмнө бичсэн, монгол орчуулгыг уйгаржин болон тод бичгээр бичсэн зэрэг ялгаатай. Төвд монгол хадмал судраас гадна тус толь бичгийн дан монгол орчуулга бүхий гар бичмэл бидний цуглуулгад байгаа боловч орчуулагчийн талаар ямар нэг мэдээ баримт мөн л байхгүй байгаа бөгөөд бид гагцхүү Зая бандид Лувсанпэрэнлэйн "Товъёг салви мэлон"-д бичсэн мэдээнд үндэслэж уул толийг Ламын гэгээн тэргүүтэй эрдэмтэд орчуулсныг мэдэж авч байгаа юм.

Бидний цуглуулгад буй хулсан үзгийн гар бичмэл "Tübed-ün dokiyan-u šastir a sayiqatur nomlaysan erdeni-yin oki qayurčay kemegdekü orusibai" хэмээх нэртэй. Хуудсыг дутуу дугаарлажээ. Бүтцийн хувьд авч үзвэл оршил, төгсгөлөөс гадна 7 хэсэгтэй. Эдгээр нь:

1. Дан-гийн дохио ялгавартай-яа номлосон бөгөөд тийн тасласан анхан
2. Ба үсгийн орц ялгавар дор номлосон, тийн тасалсан хоёрдугаар
3. Га үсэг хийгээд Да-гийн орц ялгалтай-яа номлосон гутгаар
4. А үсгийн орох ёсыг ялгалтай-яа шинжилсэн дөтгөөр
5. Ма үсгийн орох ёсыг ялгалтай-яа шинжилсэн тавдугаар
6. Толгойтын дохио ялгавартай-яа шинжилсэн зургадугаар
7. Урьдын нэрний хүчнээр хойт ямар мэтийн хүртэх ёсон тэргүүтэн

элдэв хэрэгтнийг нийт шинжлэх тийн тасалсан долдугаар гэх зэрэг дан үсэг орж бүтсэн, давхарлаж орсон, угтвар авсан байдлаар нь толгой үгсийг ангилжээ.

"Эрдэнийн охь хуурцаг" толь бичигт үг, холбоо үгийг орчуулсан байдлыг авч үзвэл төвд сударт *ka ba ka dan ka ra dang* гэснийг *багана гадан чихэр хийгээд* (baуan-a kadan siker kiged), *khruᅇg khruᅇg khral 'jal seng ge'i khri* гэснийг *могоруу алба өгөх арслангийн тавцан* (toуoriu alba ögeku arslan-u tabčang), *khruᅇg khruᅇg khri grangs sha khruᅇg dangs* гэснийг *таг туг түмэн тоо мах цусан хийгээд* (krag krig tümen toу-a miqa čisun kiged) хэмээн орчуулжээ. Дээрхи орчуулгаас үзвэл төвдөөр *гадан* (ka dan) гэсэн үгийг орчуулахгүй хэвээр хуулбарлан авчээ. Гэтэл энэ үгийг тус толь бичгээс хойно гарсан Гирдбазар, Сумадираднаагийн толь бичгүүдэд *цуудар* (čoudar), *цуударь* (čoudari), Чойдагийн толь бичигт *цагаан бөс*, С.Ч.Дасын тольд *бөс*, Ю.Н.Рерихийн тольд *нэг зүйл бөс даавууны төрөл зүйл* гэх мэт тайлбарлан орчуулжээ. *Цуудар* буюу *цуударь* гэдэг үг хятад гаралтай бололтой. Цэцэнцогтын "Монгол үгсийн язгуурын толь"-д čoubai (хятадаар "цул цагаан бөс") хэмээх үг байх бөгөөд энэ үгийн "цуу" язгуур ямар нэг хэмжээгээр *цуудар* буюу *цуударь* гэсэн үгтэй холбоотой гэж үзвэл хятад гаралтай үг байж болох талтай. Ламын гэгээн тэргүүтэй гүүш нар мөнхүү үгийг орчуулалгүй хуулан авчээ. Түүнчлэн *khal dang khral dang srad bu bkal* - *ачаа хийгээд алба хийгээд утас ээрсэн* (ači-a kiged alba kiged utasu egeregsen),

dum bur bkas dang bdun du bkug - ангид хагарсан хийгээд өмнөд ирүүлсэн (anggida qayaraγsan kiged emüenede iregüügsen),

srog bkums pa dang bkur sti dang - амин нядалсан хийгээд өргөл хийгээд (amin nituluγsan kiged ergül kiged),

smān bku ba dang bkus te bor - эм шүүслэх хийгээд шүүж огоор (em sigüüsülekü kiged sigüüjü oγoor),

bde la bkod dang zur du bkol - амгаланд зохиосон хийгээд тус тусд онцойлсан (amuγulang tur jokiyaysan kiged tus tus tur oncailaysan) гэх мэт⁹ хөрвүүлжээ. Дээр дурдсан зарим үг, холбоо үгийг хожмын толь бичгүүдэд хэрхэн орчуулсныг авч үзвэл zur du bkol гэсэн холбоо үгийг хожмын толь бичгүүдэд тусгаар гаргасан ("Эрдэнийн охь хуурцаг"-т тус тусд онцойлсан), smān bku - гэсэн холбоо үгийг хожмын толь бичгүүдэд эм чанах, эмийн сөмсийг гаргах ("Эрдэнийн охь хуурцаг"-т эм шүүслэх) гэж орчуулсан байна. Дээрхи жишээнээс үзвэл "Эрдэнийн охь хуурцаг"-ийн орчуулга хожмын орчуулгаас ямар нэг хэмжээгээр ялгаатай болох нь харагдаж байгаа юм.

Монголчууд төвд-монгол хоёр хэлний толь зохиохоос өмнө төвд толь бичгийг орчуулан хэрэглэж байсныг Ламын гэгээн Лувсанданзанжанцан тэргүүтэй мэргэдийн орчуулга харуулж байна. Монголчуудын зохиосон төвд монгол хэлний толь бичгийг авч үзвэл өнөө үед олдож буй баримтаар төвд-монгол анхны толь бичиг МЭ-ий 18 дугаар зуунд зохиогдож, 18–20 дугаар зууны хооронд томхон хэмжээний толь бичиг 20 гаруй гарчээ. Эдгээр толь бичгийг зохиосон эрдэмтэд бол урад нутгийн брова равжамба Гунгаажамц, Агваандандар лхарамба, үзэмчин гүн Гомбожав, буриадын эрдэмтэн Сумадирадна, гэвш Чойдаг, Гирдбазар, Галсанжамба, жанжаа хутагт Ролбийдорж нарын зэрэг эрдэмтэд болно.

Монголчууд толь бичиг зохиохдоо төвд мэргэдийн арга туршлагаас бүтээлчээр суралцаж байсны баримтыг монгол толь зүйчдийн бүтээлээс харж болох юм. Тухайлбал: гүн Гомбожавын "Төвдийн дохионы бичиг онохуй хялбар", Агваандандарын "Эндүүрлийг тэвчих сайн номлол үүрийн шинэхэн туяа" зэрэг толь бичгийн төгсгөлийн үгд "Даг-ег са ма дог" буюу "Эрдэнийн охь хуурцаг" толь бичгийг үндэс болгосныг тэмдэглэжээ.

Ламын гэгээн Лувсанданзанжалцан тэргүүтэй мэргэдийн 1686 онд орчуулсан "Эрдэнийн охь хуурцаг" хэмээх төвд-монгол хадмал толь бичиг 1718 онд Брова равжамба Гунгаажамцын "Төвд-монгол толь" хэвлэгдэн гарах хүртэл монголын орчуулагч гүүш нарт буддын шашны үг хэллэг, нэр томъёог төвд хэлнээс монгол хэлнээ орчуулах чухал гарын авлага болж байсан нь лавтай юм.

Энэхүү толь бичиг нэг талаас төвд, монгол толь зүйчдийн бүтээлийг судлах, нөгөө талаас монгол орчуулгын онцлогийг ажиглах, тухайн үеийн монгол хэлний онцлогийг шинжлэх чухал хэрэглэгдэхүүн болж буйгаараа ач холбогдолтой.

⁹ Bod kyi brda'i bstan bcos legs bshad pa rin po che'i za ma tog bkod pa zhes bya ba bzhugs so, гар бичмэл судар, 7а, Tübed-ün dokiyan u šastir a sayiqatur nomlaysan erdeni-yin oki qayurčay kemegdektü orusibai, гар бичмэл судар, 7б тал.

РЕЗЮМЕ

Тибетский словарь "Самадог" (za ma dog) был составлен известным тибетским учёным лексикографом Шалу Ринчэнчойжонсамбуу (1444-1527). В национальной библиотеке Монголии, в библиотеках зарубежных стран, а также в коллекции частных лиц хранится рукопись данного словаря с подстрочным монгольским переводом, а также в виде отдельного перевода.

В колофоне монгольского перевода "Эрдэнийн охь хуурцаг" (ящик драгоценности) нет данных о переводчике. О переводчике сообщает Зая бандид Лувсанпэрэнлэй (1642-1715) в своем крупном сочинении "Товъёг салви мэлон", написанном на тибетском языке.

Перевод был осуществлён под руководством Ламын гэгээн Лувсанданзанжанцана (1639-1704), известного монгольского просветителя, учёного, автора многотомных трудов по буддийской философии, медицине, астрологии.

Словарь является важным материалом в изучении монгольской лексикологии и лексикографии, специфики монгольского перевода 17-18 вв.